



САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН | 2017



Хүчтэй. Хамтдаа.

Агуулга

5	ТУЗ-ийн даргын илгээлт
11	2017 он тоогоор
15	Санхүүгийн харьцаа үзүүлэлт
17	Компанийн тухай
19	2017 оны онцлох үйл явдал
23	Гүйцэтгэх захирлын тайлан
27	Эдийн засгийн орчин
29	Гүйцэтгэлийн тойм
31	2018 оны төлөвлөгөө
33	Мөрдөх зарчим болон давуу шинж чанар
35	Үнэлгээ
37	Хөрөнгө оруулалтын багц
41	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
43	ТУЗ-ийн бүтэц
47	Хараат бус аудитын тайлан



ТУЗ-ийн даргын илгээлт

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч танаа!

Ард Санхүүгийн Нэгдлийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын хувьд та бүхэнтэй мэндчилж байгаадаа таатай байна.

ТУЗ-ийн үндсэн үүрэгт гүйцэтгэх удирдлагыг томилж, цалин урамшууллыг тогтоож, түүний ажилд хяналт тавин чиглэл өгөх чиг үүргүүд багтдаг билээ. Бид олон улсын сайн засаглалын жишгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ямагт нэвтрүүлж ажиллахыг эрмэлзэж ирсэн. Үр дүнд нь Ард Санхүүгийн Нэгдэл засаглалын хувьд Монгол Улсдаа тэргүүлэх жишиг байгууллага болсон гэдэгт бид эргэлзэхгүй байна. Энэ тайлан ч гэсэн түүний нэг илрэл гэдэгтэй та санал нийлэх буй за.

Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ 2017 онд 3 удаа хуралдаж, нэг удаа стратегийн хэлэлцүүлэг зохион байгуулсан юм. Манай ТУЗ өнгөрсөн онд 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа. ТУЗ-ийн дэргэд 3 байнгын хороо ажилладаг бөгөөд тэд тухай бүр ТУЗ-ийн хурлын бэлтгэл ажлыг хангаж ажилласан болно.

ТУЗ нь компанийн стратеги, бизнес төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, төсөв, бодлого, журам баталж, санхүү болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг авч хэлэлцэхээс гадна томоохон гүйлгээ, хэлцлийг тухай бүрт нь баталж

ажилласан билээ. Тухайлбал, МАК, ТТДС, үл хөдлөх хөрөнгийн хэлцлийг ТУЗ ээлжит хурлаараа хэлэлцсэн ба Монгол Улсад анх удаагаа криптовалютад хөрөнгө оруулж турших санаачлагыг гүйцэтгэх удирдлагад зөвшөөрсөн юм. Түүнчлэн, Ард Холдингсын мөнгөн урсгалыг хангахын тулд бид төгрөг болон долларын бонд гаргах шийдвэрийг гаргасан бол оны сүүлчээр банкнаас богино хугацааны зээл авсан билээ.

Өнгөрсөн жил бид Ард Даатгалын 12.28 хувийг нэмэн худалдан авч, Ард Бит компанийг 100 сая төгрөгөөр хөрөнгөжүүлээ. Мөн бид Ард Лайфын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, Ард Менежментэд хөрөнгө оруулах шийдвэрийг гаргасан байна.

Манай ТУЗ Ард Кредит болон Ард Даатгалын ирээдүйн өсөлтийг хангах үүднээс IPO хийх асуудлыг удаан хугацаанд нухацтай хэлэлцлээ. Ард Холдингс нээлттэй компани болох ажлын хүрээнд Жинст Увс болон Хөрөнгө Оруулагч Үндэстэн компаниуд нэгдэн хөрөнгийн бирж дээр хувьцаагаа бүртгүүлэх ажлыг бид удирдан чиглүүлж, хувьцааны үнийн өөрчлөлт, хөрөнгө оруулагчдын хандлага, зах зээл дээрх төлөв байдлыг анхааралтай ажиглаж байна.

ТУЗ-өөс компанийн бизнес төлөвлөгөөг баталж, ёс зүйн кодекс, группын нягтлан бодох

бүртгэлийн, хүний нөөцийн, ногдол ашгийн, нэгтгэсэн тайлангийн зэрэг бодлого, эрх мэдлийн хуваарилалт, мэдээллийн ил тод байдал, дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагааны журмыг тухай бүр хэлэлцэн баталсан байна.

Өнгөрөгч онд МАК хувьцаагаа худалдсантай холбогдуулан Ариунтөгс ТУЗ-ийн бүрэлдэхүүнээс гарсан бол Нэмэхбаатар өөрийн эзэмшиж буй хувьцааг Техник Технологийн Дээд Сургуулийн хувьцаагаар сольж гарлаа. ТУЗ-ийн даргын ажлыг 2013 оноос хойш тасралтгүй гүйцэтгэж ирсэн Оюунгэрэл өөрийн хүсэлтээр даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөж, ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгчээр миний бие томилогдсон болно. 2017 онд Монполимет Группын Ерөнхийлөгч Мөнхнасанг бид ТУЗ-д хараат бус гишүүнээр сонгон ажиллуулж эхэллээ. Монгол ТВ-ийн Гүйцэтгэх захирал Номин нь ХЭХ-аас ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон боловч ажлын шаардлагын улмаас өөрийн саналаар татгалзсан болно.

ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үүргийг Золзаяа онцсайн гүйцэтгэсэн бөгөөд бидний хурлын бэлтгэл ажил, хурлын явц, танилцах материал ямагт сайжирсаар ирсэн гэдгийг онцолж хэлмээр байна.

Бид Санхүү эрхэлсэн захирлын албан тушаалыг бий болгож, Эрсдлийн менежерийг томилж ажилд нь оруулаад байна. Ард Холдингс Дотоод аудитороос гадна Хууль эрхзүйн нийцлийг хариуцсан албан тушаалыг ТУЗ-д шууд тайлагнадаг болгосон нь олон улсын тэргүүний туршлагыг Монголд нутагшуулсан цөөн тохиолдлын нэг болоод байна. Ингэснээр зөвхөн Гүйцэтгэх захирлаас гадна 4 албан тушаалтан шууд ТУЗ-д тайлагнадаг боллоо.

Ард Холдингс 4 жил дараалан BDO аудитаар санхүүгийн тайлангийн аудитаа хийлгэж ирсэн бол энэ удаад Далайван аудитыг сонгон хамтран ажиллалаа. Тэдний хийсэн аудитын дүгнэлт энэ тайланд багтсан болно.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 4 сарын 23-нд амжилттай зохион байгуулж, жилийн тайлангаа хэлэлцэж, ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг сонгон, төсвийг нь баталсан.

Өнгөрсөн хугацаанд ТУЗ өөрийн гүйцэтгэлдээ үнэлэлт дүгнэлт өгч заншсан бөгөөд ТУЗ-ийн гишүүд тус бүр өөрийн гүйцэтгэлийг мөн үнэлдэг системийг бид нэвтрүүлэн хэвшүүллээ. 2016 оны хувьд бид цалин урамшууллаар нийт 176,894 ширхэг хувьцаа төсөвлөж, хувьцаа эзэмшигчдээр

батлуулж байсан бол 144,319 ширхэгийг хуваарилсан болно. Бид Гүйцэтгэх захирлын ажлыг өнгөрсөн оны 4 сарынхаа хурлаар үнэлж, цалин, шагнал урамшууллын хэмжээг тогтоож ажилласан болно.

Гүйцэтгэх захирлын 2016 оны гүйцэтгэлд ТУЗ албан ёсоор үнэлгээ өгч, нийт 85,970 ширхэг хувьцаагаар шагнасан байна.

2018 онд бид Ард Санхүүгийн Нэгдлийг нээлттэй хувьцаат компани болгон Монголын Хөрөнгийн Бирж дээр гаргахаас гадна Ард Кредит болон

Ард Даатгал компаниудыг IPO хийх замаар олон нийтэд нээлттэй болгох зорилтыг дэвшүүлж байна. Бид өөрсдийн үйл ажиллагаанд дижитал трансформацийг хэрэгжүүлэх замаар финтек банк болох зорилгодоо улам ойртож очих болно. Бидэнд өгсөн асар их итгэлийг бид хамтын зүтгэлээр хариулан ажиллана. Бид Хүчтэй. Бид Хамтдаа.

Та бүхнийхээ ажил үйлсэд амжилтын дээдийг хүсэн ерөөе!

П. Батбаяр





Эрхэм зорилго

Ашиг болон эрсдлийн хэтийн харьцааг тэнцвэржүүлэн барьснаар хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн дээд түвшинд барих бодлогыг мөрдөнө.

Алсын хараа

Бид хувьцаа эзэмшигчид болох ард иргэдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг дээдэлсэн Үндэсний хамгийн хүчирхэг санхүүгийн нэгдэл компани болно.






2017


ОН ТООГООР

Сая төгрөгөөр	2016	2017	Өөрчлөлт
Нийт хөрөнгө	39,392	49,656	26%
Зээлийн багц	5,361	2,506	-53%
Үндсэн хөрөнгө	677	825	22%
Эздийн өмч	37,466	43,112	15%
Нийт өр төлбөр	1,946	6,544	236%
Нийт ашиг	3,454	5,666	64%
Нийт орлого	2,669	3,864	45%
Нэгтгэсэн нийт хөрөнгө	39,202	49,287	26%
Нэгтгэсэн нийт ашиг	9,041	2,676	-70%
Эргэлтэнд буй нийт хувьцаа	14.15	15.03	6%
Стратегийн багц	25,561	39,033	53%
Нэгж хувьцааны өгөөж (төгрөг)	244	376.99	55%
Нэгж хувьцааны үнэлгээ (төгрөг)	2,454	2,955	20%

Цэвэр ашиг (сая төгрөг)



Зээлийн багц (сая төгрөг)



Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөг)



Нэгж хувьцааны үнэлгээ (төгрөг)



Компанийн нийт хөрөнгө 26 хувь өсч 49.7 тэрбум төгрөгт хүрсэн нь манай стратегийн хөрөнгө оруулалтын багцын үнэлгээ 53 хувь өсч 39 тэрбум төгрөгт хүрсэнтэй шууд холбоотой юм. Тэр дундаа 2017 онд Монгол Шуудан ХК-ийн зах зээлийн үнэлгээ 63 хувь өсч 16 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд Ард Кредит болон Ард Даатгал компаниудад эзэмшдэг манай хувьцааны үнэлгээ 19 болон 24 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Тайлант жилд манай нийт зээлийн багцын хэмжээ 53 хувиар буурч 2.5 тэрбум төгрөгт хүрсэн нь ТТДС-аас авах 3.1 тэрбум төгрөгийн зээлийг тус сургуулийн хувьцаа болон үл хөдлөх хөрөнгөөр солилцох хэлэлцээр хийж хаасантай холбоотой.

2017 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь үйл ажиллагаанаас 1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд үүн дээр 4.6 тэрбум

төгрөгийн хөрөнгө оруулалтын үнэлгээний ашиг нэмэгдэж, нийт 5.6 тэрбум төгрөгийн дэлгэрэнгүй ашигтай ажилласан байна. Үр дүнд нь компанийн эздийн нийт өмч 15 хувь нэмэгдэж 43 тэрбумд хүрсэн юм.

Хөрөнгө оруулалтын компанийн хувьд бид энэ жил үйл ажиллагааныхаа болон хөрөнгө оруулалтын мөнгөн хэрэгцээг хаалттай хүрээнд бонд гаргах, банкнаас зээлийн шугам нээлгэх зэргээр санхүүжүүлсэн билээ. Үр дүнд нь манай нийт өр төлбөрийн хэмжээ 236 хувь өсч 6.5 тэрбум төгрөг болов. Энэхүү өсөлтөд мөн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлттэй холбоотой хойшлогдсон татварын өглөг 1,292 сая төгрөг орсон болно.

Компанийн нийт үнэлгээ 19 хувиар өсч, нэгж хувьцааны үнэлгээ мөн тэр хэмжээгээр нэмэгдэв.



Санхүүгийн харьцаа үзүүлэлт

	2016	2017	Өөрчлөлт
Зээлийн багц/Хөрөнгө	13.6%	5.1%	-8.6%
Хөрөнгө оруулалт/Хөрөнгө	64.9%	78.8%	13.9%
Өр төлбөр/Хөрөнгө	4.9%	13.1%	8.2%
Хөрөнгө оруулалт/Өөрийн хөрөнгө	68.2%	90.7%	22.5%
Цалингийн зардал/Нийт зардал	25.8%	13.4%	-12.4%
Санхүүгийн зардал/Нийт өр төлбөр	11.1%	6.1%	-5%
Үйл ажиллагааны зардал/Хөрөнгө	4.6%	5.5%	0.9%
ROE (өөрийн хөрөнгийн өгөөж)	9.2%	13.1%	3.9%
ROA (нийт хөрөнгийн өгөөж)	8.8%	11.4%	2.6%

Зээлийн багцыг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа буурсан нь ТТДС-аас авах зээлийн үлдэгдэл болох 3.2 тэрбум төгрөгийг тус сургуулийн хувьцаа болон үл хөдлөх хөрөнгөөр хаасантай холбоотой. Хөрөнгөд эзлэх зээлийн хэмжээ буурсан нь бид сул байгаа бүхий л эх үүсвэрийг хөрөнгө оруулалтад зориулж ажиллаж байгааг илтгэнэ.

Манай нийт хөрөнгөд эзлэх стратегийн хөрөнгө оруулалтын багц өсч 78.6 хувьд хүрсэн нь Монгол Шуудан, Ард Даатгал, Ард Кредитын үнэлгээ өсч үнэ цэнийг нэмэгдүүлснээс гадна Ард Даатгал, ТТДС болон КристоҮндэстэнд шинээр оруулсан хөрөнгө оруулалтын нөлөө юм.

2017 онд бид төгрөг болон долларын дунд хугацааны бонд гаргасан нь өр төлбөр болон хөрөнгийн харьцааг 4.9 хувиас 13.2 хувь хүртэл өсгөлөө. Ингэснээр бид арилжааны банкны хамаарлыг багасган хөрөнгийн зах зээлээс эх үүсвэр босгох боломжоо тэлж чадлаа.

Бид хаалттай хүрээнд бонд босгох замаар 2016 оны эх үүсвэрийн зээл дахин бүтэц хийснээр 2.9% бууруулж 2017 оны дундаж хүүгийн 18.76% хувьд хүргэв.





Компанийн тухай

Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрс Коор төрийн бус байгууллага ХасБанкны нийт ажиллагсад зориулан 600 сая төгрөгийг ажиллагсдын хувьцаа эзэмшүүлэх санд хандивлах шийдвэрийг гаргасан юм.

Улмаар ХасБанкны ажиллагсад тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилгоор өөрийн хувьцаагаа ХасБанкны толгой компани болох ХАС-ГЭ ХХК-ийн хувьцаагаар солих байдлаар хөрөнгө оруулалт хийсэн болно.

ХАС-ГЭ ХХК нь тухайн үеийн удирдлагын шийдвэрийн дагуу ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болж өөрчлөгдсөн бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг томоохон компаниудын нэгдэл болж өргөжсөн билээ.

Ард Санхүүгийн Нэгдэл нь 2005 оны 9 дүгээр сард ХасБанкны үүсгэн байгуулагч гүйцэтгэх удирдлагын санаачлагаар “Employee Investment Trust” буюу ИАЙТи ХХК нэртэйгээр байгуулагдсан бөгөөд Монголын анхдагч институционал хөрөнгө оруулагчийн үндэс суурийг тавьсан түүхтэй.

ИАЙТи нь 2005 онд үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн дүрмийн сантай, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 3,000 гаруй хувьцаа

эзэмшигчтэй, 50 орчим тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж өргөжсөн байна.

2013 онд манай гол хувь нийлүүлэгчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрэн дор үйл ажиллагаагаа явуулах түүхэн шийдвэрийг гаргасан юм. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд бид Ард Кредит, Ард Даатгал, Ард Секюритиз, Ард Лайф болон Ард Активд тасралтгүй хөрөнгө оруулж эхэлсэн билээ. 2016 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр болсон томоохон хувьчлалд амжилттай оролцож Монгол Шуудан ХК-ийн гол хөрөнгө оруулагч нь болж чадсан юм. 2017 онд манай үндсэн хөрөнгө оруулалтын багцад хөрөнгө оруулалтын сангийн удирдлагыг хэрэгжүүлэх Ард Менежмент, криптовалютын арилжаа эрхлэх Ард Бит компаниуд нэмэгдсэн байна. 2018 оноос ТэнГэр Системс компани өөрийн үйл ажиллагааны чиглэлд шинэчлэл хийж, блокчэйн технологи руу шилжиж эхлэв.

Бид бүтээсэн баялгаасаа хувь хүртэх ёстой, харилцагч иргэн бүр банкныхаа эзэн нь байх ёстой гэсэн итгэл үнэмшилдээ хөтлөгдөн 2015 онд Ард Холдингсыг хаалттай хувьцаат компани болгосон билээ. 2017 оны төгсгөлд Хөрөнгө Оруулагч Үндэстэн Жинст-Увс нээлттэй ХК-тай урвуу хэлбэрээр нэгдэж МХБ дээр арилжаалагдаж эхэлсэн нь бид 2018 онд нээлттэй компани болох бэлтгэл ажил хангагдсаныг нотолсон юм.



2017 оны онцлох үйл явдал

2017 онд хамгийн олон хүнийг хамруулсан төр засаг, олон нийт болон салбарын мэргэжилтний төлөөлөл бүхий Хөрөнгө Оруулагч Үндэстэн чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулсан.

Бид энэ жил анх удаагаа 2 тэрбум төгрөгийн болон 1 сая долларын бондыг тус тус зах зээл дээр гаргаж хаалттай арилжаалав.

Бид Ард Даатгал компанийн эзэмшлийн хувиа нэмэгдүүлж 95 хувийг нь эзэмших болсон бөгөөд гүйцэтгэх захирлаар Цогбадрахыг томилон ажиллуулж эхэллээ.

Ард Академиас сургалт тогтмол зохион байгуулж ирсэн бөгөөд Миний Анхны Хөрөнгө Оруулалт болон Цахим Алт номыг бичиж хэвлүүлэв.

Техник Технологийн Дээд Сургуульд эзэмшиж байсан 50 хувиа худалдсан бөгөөд оны эцсээр 12 хувийг эргүүлэн худалдан авах шийдвэрийг гаргалаа.

Ард Бит компанийг шинээр үүсгэн байгуулж, Запо (Харо.com)-той хамтран Биткойн зуучлан ажиллаж эхэлсэн бөгөөд байгуулагдсанаас хойш богино хугацаанд ашигт ажиллагаанд хүрч чадлаа.

Шангри Ла Молл дахь анхны салбараа нээн туршилтаар ажиллуулж эхэлсэн ба бүх төрлийн санхүүгийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг өгөх зорилготой юм.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийг МХБ дээр бүртгэлтэй Жинст Увс ХК-тай нэгтгэх байдлаар нээлттэй хувьцаат компани болгон өөрчилсөн бөгөөд Монгол Улсад анх удаа урвуу нэгдэл (RTO) хэлбэр бүхий хэлцлийг амжилттай хийж гүйцэтгэв. Хувьцааны 2017 оны арилжааны хаалтын ханш 1,858 төгрөг болов.

Криптовалют болон блокчэйн технологийн талаар ард иргэдэд тэгш мэдээлэл өгөх, энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад үйлчилгээгээ танилцуулах боломж өгөх, гадны мэргэжилтнүүдийн туршлагыг сонсох зорилготой бодлого тодорхойлогч нарын оролцоог хангасан Кripto Үндэстэн чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулж 3,000 гаруй хүн оролцлоо. Энэ нь Монголд зохиогдсон анхны ийм төрлийн хурал юм.

Кripto валютын зах зээл рүү нэвтрэн орох стратегийн хүрээнд 153 хөрөнгө оруулагч бүхий блокчэйн олборлолт болон криптовалютын сагсанд хөрөнгө оруулах зорилготой КriptoҮндэстэн хөрөнгө оруулалтын тусгай зориулалтын компанийг үүсгэн байгуулж нийт 950 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Банк санхүүгийн програм хангамжийн салбартаа тэргүүлэгч Грэйп Сити болон Мост Мони компаниудтай стратегийн түвшинд хамтран ажиллах гэрээ үзэглэв.

Ард Кредит болон Ард Активын үйл ажиллагаа хоорондоо уялдаатай өргөжиж байгаа бөгөөд цаашид улам нягтрах боломжтой. Энэ хоёр компани нь бидний арилжааны банктай болох зорилгын хоёр тулгуур багана юм.







Гүйцэтгэх захирлын тайлан

Бонд, Биткойн, Бирж – 3 “Б”-гийн жил

2017 онд бид өмнө нь санаачилж эхлүүлсэн зарим ажлаа зангидан нэгтгэж, эцсийн үр дүнг нь гаргах, шинэ эх үүсвэр татан төвлөрүүлж, өмнө нь ужгираад байсан асуудлаа бүрэн шийдэхийг оролдсон жил байлаа.

Бид банкны зээлээс бүрмөсөн чөлөөлөгдөж, иргэдээс Бондын эх үүсвэрийг хаалттай хүрээнд татан төвлөрүүлэх туршилт маань амжилттай хэрэгжиж, Ард Санхүүгийн Нэгдэл болон Ард Кредит тус бүр анхны бондоо амжилттай гаргалаа. Долларын бонд гаргах туршилтыг ч эхлүүлсэн бөгөөд энэхүү үйл явцад бид зах зээл, манай бүтээгдэхүүн, боловсон хүчний нөөц болон дотоод системээ сайтар шалгаад авлаа.

Би хувиараа 2016 оны сүүлчээс эхлэн Биткойны талаарх мэдээллийг олон түмэндээ түгээж эхэлсэн бол энэ талаарх судалгаа, шинжилгээгээ лавшруулж, Ард Академийн сургалтын хөтөлбөртөө оруулахаас гадна Ард Бит нэртэй компани байгуулан Биткойныг анх удаа Монголд шууд авах боломжийг нээж өгсөн юм. Бид КriptoҮндэстэн Форумыг зохион байгуулж, Цахим Алт нэртэй номоо хэвлэж, олны хүртээл болголоо. 8 дугаар сарын ТУЗ-ийн хурлаас бид анх удаа байгууллагын мөнгөөр криптовалютын багцад хөрөнгө оруулалт хийсэн юм. Тэрхүү

багц маань оны сүүлчээр 250 хувийн өсөлтийг үзүүлсэн бол бид 12 дугаар сард КriptoҮндэстэн нэртэй Монголын анхны хаалттай крипто хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгууллаа.

Бид Монголын Хөрөнгийн Бирж дээр өөрийн хувьцаагаа арилждаг Монголын анхдагч санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болох зорилгодоо хурч чадлаа. 12 дугаар сарын 15-ны өдөр бидний хувьд түүхэн өдөр болж тэмдэглэгдэн үлдэх болно. Энэ өдөр Хөрөнгө Оруулагч Үндэстнийг Жинст Увстай нийлүүлэх замаар хувьцааг нь олон нийтэд чөлөөтэй арилжаалж эхэлсэн бөгөөд Монголчууд өөрийн үйлчлүүлдэг банкныхаа хувьцааг авч, эзэн суух үүд хаалга жинхэнэ утгаараа нээгдсэн болно. Харин 2018 онд бид Ард Санхүүгийн Нэгдлийг Хөрөнгө Оруулагч Үндэстэнтэй нэгтгэх ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Бид хамтдаа хамгийн хүчирхэг банк, санхүүгийн нэгдэл болж өргөжин хөгжих зорилгыг дэвшүүлэн шилдэг технологийг дайчилсан, шилмэл мэргэжилтнүүдийг ажиллуулсан Ард Банк – Зөв Банкныг байгуулах ажилдаа ханцуй шамлан орлоо.

Ард Санхүүгийн Нэгдлийн баг миний удирдлага дор олон нийтэд хувьцаагаа арилжаалдаг тэргүүлэх санхүүгийн нэгдэл болох, дижитал

технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн финтек/банк болох гэсэн 2 том бөгөөд тодорхой зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа.

Нэгдүгээр зорилтын хүрээнд бид Хөрөнгө Оруулагч Үндэстнийг Жинст Увстай нэгтгэн Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцааг нь амжилттай арилжиж эхэлсэн юм. Манай ТУЗ-өөс Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Кредит, Ард Даатгал компаниудын хувьцааг олон нийтэд нээлттэй арилжих байдлаар хөрөнгө босгохыг зөвшөөрсөн ба энэ ажил бүгд 2018 онд биеллээ олох боломжтой болж байна. Бид компанийн засаглал, дотоод хяналт, ил тод байдал, эрсдлийн удирдлага, тайлагналын системд бүх талаар тодорхой ахиц дэвшлийг гаргаж ажиллалаа. Манай багийнхан олон түмэнд үйл ажиллагаагаа танилцуулж, сурталчлах зорилгоор Хөрөнгө Оруулагч Үндэстэн болон Крипто Үндэстэн Чуулга Уулзалтыг амжилттай зохион байгуулж, хоёр ч ном бичин олон түмний хүртээл болгов.

Финтек болох хоёрдахь зорилтын хүрээнд Ард Кредит Худалдаа Хөгжлийн Банкны ко-бренд картыг гаргаж, Грэйп Сити компанитай стратегийн түншлэлийн гэрээг байгуулав. Энэ гэрээний хүрээнд Ард Кредитэд банкны Поларис системийг нэвтрүүлж эхэлсэн ба Мост Монитор хамтран ажиллахаар болов. Монгол Шуудангийн салбаруудтай хамтран санхүүгийн үйлчилгээг үзүүлэх ажлын хэсгийг байгуулж ажил эрчтэй урагшилж байна. Бидний байгуулсан Ард Бит компани Запо (Харо.com)-той хамтран ажиллаж байгаа ба ингэснээр бид Биткойныг Монголд анхлан арилжиж эхэлсэн билээ. Ард Активын бүх

төрлийн хадгаламж нь энэ төрлийн даатгагдсан анхны бүтээгдэхүүн болж, 130 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Бид криптограф болон блокчэйн технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд боловсон хүчнээ бэлтгэх зорилгоор Блокчэйн Академийг үүсгэн байгуулав. Дижитал технологийн нэвтрүүлэлтийн ажлыг зангидан ажиллах албан тушаалтныг томилж ажилд нь орууллаа.

Манай баг нягтлан бодох бүртгэлийн програмаа шинэчилж, нэгдсэн програм хангамжийн бодлогоо тодорхойлж ажиллалаа. Дижитал зах зээлийг эхлүүлэхээр бид ard.mn хаяган дээр хөгжүүлэлт хийж байгаа ба 2018 онд онлайн худалдааны төвлөрсөн платформыг байгуулан ажиллах болно. Монгол Шуудан, хөдөөгийн хоршоод, Азийн Хөгжлийн Банкны төсөл, Мост Мони, криптовалютын арилжаа, эксченж, хэтэвч, блокчэйн, хувьцааны онлайн арилжаа явуулах платформ, бүх компаниудыг нэгтгэсэн датабааз, огтлолцоо борлуулалт, фэйсбүүк банкинг зэрэг ажил үйлчилгээг нэвтрүүлэхэд бид бэлэн болов.

Бидний хувьд 2017 он амжилт бүтээлээр дүүрэн жил байсан бол 2018 он хувьцаа эзэмшигч та бүгдэд очих ашиг, үр өгөөжийг улам бүр нэмэгдүүлсэн жил байх болно. 2017 оны онцлох үйл явдлууд, 2018 оны төлөвлөгөө болон танд хэрэгтэй бусад мэдээллийг энэхүү тайлангаас үзэж танилцана уу.

Хүчтэй – Хамтдаа!

Хутагт овгийн Чулууны Ганхуяг





Эдийн засгийн орчин

Улсын эдийн засаг тогтворжих замдаа орж, 2017 оны гүйцэтгэлээр 5.1 хувьд хүрч өсөв. Гадаад валютын нөөц нэг жилийн дотор 2.5 дахин нэмэгдэж 3.2 тэрбум доллар болсон бол экспорт анх удаа зургаан тэрбум долларт хүрч өсөн гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.1 тэрбум долларт хүрлээ. Засгийн Газар 1.1 тэрбум доллар буюу 2.6 их наяд төгрөгийн өрийг төлж барагдуулснаар өр, зээлийн дарамтаас гарч чадлаа. Ингэснээр дэлхийн голлох үнэлгээний агентлагууд Монголын зээлжих зэрэглэлийг нэг шат ахиулан, Монгол Улс тогтвортой гэсэн ангилалд орлоо. Төсвийн алдагдал өмнөх жилтэй харьцуулахад хоёр дахин буурч, ДНБ-ий өсөн хувьд хүрэв. Нэгдсэн төсвийн орлого 660 тэрбум төгрөгөөр давж биеллээ.

Шинэ он гарснаас хойш УИХ-аас холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг хуучин хэвд нь оруулан, тэтгэвэрт гарах насыг сонголттой болгосон нь бидний цаашдын үйл ажиллагаанд сайнаар нөлөөлж байна.

Банкны салбарын нийт актив 28.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оныхоос 13.6 хувиар өссөн бөгөөд үүнд арилжааны банкуудын төв банкинд хийсэн нөөцийн 2.9 их наяд төгрөгийн өсөлт, дотоодын зээлийн цэвэр дүнгээр 1.1 их наяд төгрөгийн өсөлт тус тус нөлөөлсөн байна. Мөн

энэ онд Монголбанкнаас банкуудын Активын чанарын үнэлгээний ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн талаар мэдээлсэн билээ.

Даатгалын салбарын нийт хөрөнгө 244.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 17.4 хувиар өссөн байна. Нийт хураамжийн орлого 144.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 26.1 хувийн өсөлтийг харуулж байгаа бөгөөд үүний 46.6 тэрбум төгрөг буюу 32.3 хувь нь давхар даатгалын хураамж байжээ. Нөхөн төлбөрийн зардал 45.2 тэрбум төгрөг байсан нь өмнөх оны дүнгээс 31.9 хувиар өссөн байна.

Банк бус санхүүгийн байгууллагын нийт актив 969.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 23.1 хувиар, нийт орлого 195.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 2.5 хувиар, цэвэр ашиг 66.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 7.8 хувиар тус тус өссөн байна. 2017 оны байдлаар нийт пассивын 4 хувийг итгэлцлийн үйлчилгээний өглөг, 11.6 хувийг дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг, 78.2 хувийг эздийн өмч тус тус бүрдүүлж байжээ.

Үнэт цаасны арилжаа 860.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 147 хувиар өссөн бөгөөд үүний 9 хувийг хувьцааны арилжаа, 90 хувийг ЗГҮЦ-ны арилжаа, 1 хувийг компанийн бонд бүрдүүлсэн байна. Хувьцааны арилжааны индексийн хувьд

Топ-20 20,736.93 нэгж болсон нь 66.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин MSE ALL индекс 1,146.31 нэгжид хүрсэн нь 33.1 хувийн өсөлтийг илтгэж байна. Хөдөө аж ахуйн биржийн хувьд арилжаа 572.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 23.7 хувиар өссөн үзүүлэлттэй байлаа.

Хадгаламж, зээлийн хоршооны нийт актив 153.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 35.4 хувиар өссөн бөгөөд нийт гишүүдийн тоо 20.4 хувиар өссөн байна. Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл 99.3 тэрбумд хүрсэн нь өмнөх оноос 45.8 хувиар өссөн үзүүлэлт болжээ. ХЗХ-дын нийт ашиг 5.5 тэрбумд хүрч өмнөх оныхоос 44.7 хувиар өссөн байна.



Гүйцэтгэлийн ТОЙМ

2017 онд манай нийт хөрөнгө 39.4 тэрбум төгрөгөөс 49.7 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнд, манай баланс дээрх хамгийн чухал үзүүлэлт болох стратегийн буюу урт хугацаат хөрөнгө оруулалтын багцын өсөлт нөлөөлж 25.6 тэрбум төгрөгөөс 39 тэрбум төгрөгт хүрч 52.7 хувиар өслөө. Энэ өсөлтийг нийт 2.8 тэрбум төгрөгийн бонд, 1.1 тэрбум төгрөгийн банкны зээл болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн бол үлдсэн дүн нь манай дотоод үнэ цэнийн өсөлтөөр бий болсон баялаг юм. Бид 2017 онд 5.6 тэрбум төгрөгийн нийт дэлгэрэнгүй ашигтай ажиллалаа.

Манай хувьцаа эзэмшигчдэд хамгийн ихээр сонирхолтой байж болох өөрийн хөрөнгө маань 37.5 тэрбумаас 43.1 тэрбум төгрөгт хүрч, 15 хувиар өссөнөөр нэгж хувьцааны дотоод үнэлгээ 20 хувиар өсч 2,955 төгрөгт хүрлээ.

2017 онд нийт 8,682.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 4,385,887 ширхэг Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа хоёрдогч зах зээл дээр арилжаалагдсан байна. 2017 онд хувьцааны нээлтийн ханш 2,100 төгрөг байсан бол хөрөнгө оруулалттай компаниудын ашигт ажиллагаа, үнэлгээ болон эрэлттэй холбоотойгоор хаалтын ханш 2,500 төгрөг боллоо.

Үнэлгээнд Монгол Шуудангийн хувьцааны өсөлт хамгийн ихээр нөлөөллөө - түүний зах

зээлийн үнэлгээ нэг жилийн дотор 65.9 хувиар өсч, нэгж хувьцааны үнэ 2017 оны эцэст ханш 552.50 төгрөгөөр хаагдсан юм. Ингэснээр Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшиж буй хувь 16 тэрбум төгрөгт хүрч, манай стратегийн багцад 41.1 хувийн жинг эзэлж эхэллээ. Монгол Шуудан 2017 онд 1.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд үүний 30 хувь буюу 367 сая төгрөгийг ногдол ашгаар 2018 онд хуваарилахаар шийдвэрлэжээ. Монгол Шуудангийн нэмэлт хувьчлалын асуудал тодорхойгүй хэвээр байна. Тус компанийн үйл ажиллагаа сайжирсаар байгаа бөгөөд компанийн засаглалыг улам бүр бэхжүүлэх зайлшгүй шаардлага бий.

Ард Даатгалын манай багц дахь үнэлгээ 7.7-оос 9.5 тэрбум төгрөгт хүрч, 24 хувийн өсөлт гаргаж, тус компани стратегийн багцад 24.4 хувийг эзэлж байна. Ард Холдингс компанийн 95.31 хувийг эзэмшиж байна. Ард Даатгал 2017 онд 1,123 сая төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд үүнийхээ 50 хувийг ногдол ашгаар хуваарилахаар тогтлоо. 2018 оны эхний хагаст дүрмийн санг 1.5 тэрбумаар нэмэгдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд үүнийг IPO хийх замаар шийдвэрлэхээр болов.

Эдгээрийн араас удаалж байгаа Ард Кредитын үнэлгээ нь цэвэр ашгийн нөлөөллөөр 19 хувиар өсч 4.6 тэрбум төгрөгт хүрлээ. Ард Кредит манай

стратегийн багцад 11.7 хувийг эзэлж байгаа бол Ард Холдингс түүний 80.7 хувийг эзэмшдэг. 2017 оны хувьд Ард Кредит нийт хөрөнгөө 10 тэрбум төгрөгт хүргэж, 641 сая төгрөгний цэвэр ашигтай ажиллалаа. Өнгөрсөн жил тэд кредит картыг зах зээлд нэвтрүүлж, системийн шинэчлэлийг хийснээр 2018 онд цахим банкны үйлчилгээг үзүүлэхэд бэлэн болов. Ард Кредит 4 дэх жилдээ тасралтгүй ногдол ашиг хуваарилж байгаа бөгөөд 2018 онд IPO хийхэд бэлэн боллоо.

Бусад жижиг компаниудын үнэлгээнд зарчмын өөрчлөлт ороогүй бол бид Техник Технологийн Дээд Сургуульд оны эцэст дахин хөрөнгө оруулах шийдвэрийг гаргаж, 12.41 хувийг нь эзэмшиж эхэллээ. Мөн КриптоҮндэстэн санд нийт 950 сая төгрөгийн хөрөнгө оруулсан нь багцад гарсан гол өөрчлөлтөд тооцогдоно. Харин Алтан Хоромсог ҮЦК-г бид анхдагч өртөг болох 40 сая төгрөгөөр худалдав.

Манай бусдад олгосон зээлийн багц 2.8 тэрбум төгрөгөөр буурч, авлагын хэмжээ 418 сая төгрөгөөр өсчээ.

Бид үл хөдлөх хөрөнгө оролцуулсан хэлцэл нэлээдгүй хэдийг хийсэн бөгөөд ТТДС-ийг худалдахад оролцуулж авсан Хийморийн 3 таунхаусын нэгийг нь Ард Даатгалын 10.27 хувийг худалдан авахад зарцуулж, мөн нэг таунхаусыг Найман Шарга хотхон дахь 2 байшингаар сольж авлаа. Ард Даатгалын эзэмшилд байсан Сити Тауэрын офисын барилгыг оролцуулан МАК-аас Ард Санхүүгийн Нэгдлийн 873000 ширхэг хувьцааг тус бүрийг нь 2,500 төгрөгөөр үнэлж авсан наймаанд үлдсэн нэг таунхаусыг шилжүүлсэн болно. Ингэснээр Ард Санхүүгийн Нэгдэл ХК оны эцэст Найман Шаргын нийт 1.2 тэрбумын өртөгтэй 2 байшин, Гачууртын 193 сая төгрөгийн үнэтэй 2 га газартай, Өнгөт Хэвлэлийн үл хөдлөх хөрөнгө 1.7 тэрбумын өртөгтэй хөрөнгөтэй гарсан бол Ард Даатгалын нэр дээр Хийморийн нэг таунхаус болон 750 м2 үйлдвэрийн байр бүртгэлтэй байна. Ард Даатгалд авлага барагдуулах явцад шилжиж ирсэн хоёр орон сууцыг урт хугацаат эзлээр борлуулж, Ард Кредитэд шилжүүлсэн байна.



2018 оны ТӨЛӨВЛӨГӨӨ

Хувьцааны үнэ цэнийг өсгөх

2018 онд бид хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны үнэ цэнийг өсгөж, хөрвөх чадварыг сайжруулах зорилтыг тэргүүн ээлжинд тавин ажиллах болно. Энэхүү ажлын хүрээнд бид стратегийн хөрөнгө оруулалттай охин компаниуд болох Ард Даатгал болон Ард Кредит дээр IPO хийж МХБ дээр нээлттэй арилжаалагддаг компани болгох төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа билээ. Ингэснээр тус компаниудын өөрийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэхээс гадна зах зээлийн бодит үнэлгээ тогтох юм. Үүний үр дүнд манай стратегийн багцын 77.2 хувийг эзлэх, хамгийн том 3 аж ахуйн нэгжийн үнэлгээ хөрөнгийн зах зээл дээр тодорхойлогдох бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэлийн үнэлгээ илүү үндэслэл сайтай болж хувьцааны үнэ нь өснө гэсэн тооцоотой байна. Улмаар бид Жинст Увс буюу Хөрөнгө Оруулагч Үндэстэнтэй Ард Холдингсыг нэгтгэх замаар Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа арилжаалж эхлэх юм.

Бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулах

Бид мэдээлэл технологийн хөгжлийн давуу талыг ашиглан бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол Улсын өнцөг булан бүрт салбаргүйгээр хүргэдэг финтек компани болох зорилготой ажиллаж байна. Манай компани 2017 оны 12 дугаар сард Грэйп Сититэй стратегийн түвшинд хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд 2018

оноос эхлэн группын хэмжээнд үндсэн системдээ хөрөнгө оруулалт хийж эхлэх юм. Үүний үр дүнд бид хэд хэдэн шинэлэг бүтээгдэхүүнийг зах зээл дээр нэвтрүүлж эхлэх ба цаашид манай үйлчилгээний өрсөлдөх чадвар нэмэгдэнэ гэж тооцож байна. Бид Монгол Шуудантай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, тэдний дэд бүтцийг ашиглан санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй байдлаар хүргэх ажлыг эхлүүлээд байна.

Шинэ технологи нэвтрүүлэх

Анх интернет хөгжин дэлгэрэх үед Монголчуудад дэлхийн өндөр хөгжилтэй орнуудтай зэрэгцэн хөгжих боломж гараагүй бол энэ удаа хиймэл оюун ухаан болон блокчэйн технологи бидэнд асар их боломжийг олгож байгаа гэж бид үздэг. Тиймээс ч бид энэхүү шинэ технологийг сайтар судлан хүний нөөцөө бэлдэж, шинэ төслүүдэд хөрөнгө оруулалт хийж эхлээд байна. 2017 онд бид Ард Бит ХХК-ийг байгуулан Монголчуудад биткойн болон алткойны худалданд оролцох боломжийг анхлан олгосон бол энэ жилээс эхлэн криптовалютыг хүн бүр хэрэглэж, хөрөнгө оруулахад илүү ойр, хялбар болгох тал дээр тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх болно. Тэнгэр Системс үйл ажиллагаагаа блокчэйн технологи дээр суурилсан шийдлүүдийг гаргах тал руу чиглүүлж, хажуудаа Блокчэйн Академийг байгуулан ажиллаж байна.



Мөрдөх зарчим болон Давуу шинж чанар

Мөрдөх зарчим

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллана;

Ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоон дагаж, Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох журам зааврыг чандлан мөрдөнө;

Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэлийн харьцааг зохистой түвшинд барьж ажиллана;

Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлэн ажиллана;

Нээлттэй уян хатан бодлого баримталж, зах зээлийн мэдрэмжтэй, хурдан шуурхай ажиллахыг эрхэмлэнэ;

Зах зээлд шинийг нэвтрүүлж, тэргүүлэх бодлогыг Ардын хөрөнгө оруулалттай компаниуд мөрдөж ажиллана;

Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг Ардын хөрөнгө оруулалттай компаниуд чандлан мөрдөнө;

Хамгийн хүчирхэг, мэргэжлийн, цомхон, үйл хэрэгтээ үнэнч хамт олныг бүрдүүлж ажиллах бөгөөд шинээр ажилд орох босгыг өндөрт тогтоож, ажлын байранд тавигдах шаардлага, хариуцлагыг чанд мөрдөнө.

Давуу шинж чанар:

Үндэсний хөрөнгө оруулалттай санхүүгийн цогц үйлчилгээ бүхий нэгдэл;

Амжилттай хөрөнгө оруулалтын туршлага, ил тод засаглал, тэргүүний менежмент;

Санхүүгийн салбарт шинэ санаа, төслийг хэрэгжүүлэгч хамт олон;

Технологийн дэвшил, зах зээлийн мэдрэмж, туршлагатай маркетингийн баг;

Нэр хүнд бүхий компани, хувь хүмүүсийн сэтгэл шингэсэн хөрөнгө оруулалт;

Өрсөлдөх чадвар, үр ашгийг цогцлуулсан түншлэл;

Хөрөнгө оруулалтын тогтвортой өгөөж;


Зах зээлийн боломжийг хөрөнгийн үнэ цэнэ болгох туршлага.





ҮНЭЛГЭЭ

(сая төгрөг)	Q4 2015	Q4 2016	Q4 2017
Стратегийн хөрөнгө оруулалт	9,405	23,599	33,712
Монгол Шуудан	-	9,681	16,065
Хөрөнгө Оруулагч Үндэстэн	58	162	296
Ард Даатгал	6,337	7,689	9,528
Ард Кредит	1,853	3,818	4,558
Ард Секюритиз	983	2,126	2,126
Ард Менежмент	100	100	100
Ард Актив	64	13	29
Ард Лайф	10	10	1,010
Стратегийн бус хөрөнгө оруулалт	11,438	2,077	5,341
ТэнГэр Системс	190	199	274
Номын Хишиг	1,382	1,780	1,780
ТТДС	9,825	-	2,337
КриптоҮндэстэн Сан	-	-	950
Бусад	41	98	-
Бусад	8,506	9,048	5,372
Богино хугацаат хөрөнгө оруулалт	3,326	8,304	1,310
Үндсэн хөрөнгө	1,623	726	873
Бэлэн мөнгө	1,328	166	689
Цэвэр авлага	2,229	-864	2,500
Хөрөнгө борлуулсны олз	-	716	-
Нийт үнэлгээ	29,349	34,724	44,425
Гүйлгээнд байгаа хувьцааны тоо	13,486,359	14,151,451	15,033.87
Нэгж хувьцааны үнэ	2,176	2,454	2,955



Хөрөнгө оруулалтын багц

Ард Даатгал

Ард Даатгал 10.3 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллаж өмнөх оныхоос 40 орчим хувийн өсөлт үзүүлж, нийт 3,408 даатгуулагчдад 4.1 тэрбум төгрөгийн хохирлыг төлж барагдуулан даатгалын гэрээний үүргээ нэр төртэйгээр биелүүллээ. Үүний дүнд 1.12 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд өөрийн хөрөнгийн өгөөж 23.7 хувьтай гарлаа.

2017 онд Ард Даатгал компани үйлчилгээний чанарт онцгой анхаарч, харилцагчдаа сэтгэл ханамжтай байлгахыг хичээн ажилласан. Нөхөн төлбөрийг энгийн үед дунджаар ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэж байгаа бөгөөд шинэ жил, цагаан сарын баяр ёслолын үеэр 500 мянга хүртэлх дүнтэй нөхөн төлбөрийг өдөрт нь шийдэж, шуурхай үйлчилгээг хэвшил болгож, харилцагчдынхаа талархлыг хүлээлээ.

Ард Кредит

2017 онд Монгол Улсын эдийн засгийн байдал сэргэхтэй зэрэгцээд Ард Кредитын үйл ажиллагаа эрс сэргэж, санхүүгийн үзүүлэлтүүд сайжирсан жил боллоо. Тайлант хугацаанд манай компанийн нийт хөрөнгийн хэмжээ 79 хувь өсч 10.2 тэрбум, цэвэр зээлийн багц 60 хувь өсч 7.8 тэрбум төгрөгт тус тус хүрсэн бол 640 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өмнөх жилүүдтэй харьцуулахад

хамгийн өндөр үзүүлэлт байлаа. Бид кредит картын үйлчилгээг олон нийтэд нэвтрүүлсэн анхны ББСБ болж нийт 416 Ард кредит картыг гаргасан бөгөөд цаашид зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн нэвтрүүлэн үйл ажиллагаагаа хурдацтай өргөжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Ард Секюритиз

2017 онд Ард Секюритиз ҮЦК бүтцээ хоёр удаа өөрчилж, удирдлага нь хоёр удаа солигдсон хөдөлгөөн ихтэй жил боллоо. Компанийн ТУЗ тухай бүрт хуралдаж холбогдох шийдвэр, үйл ажиллагааны чиглэлүүдийг гаргаж ажиллалаа.

Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд компани нь гурван удаагийн төгрөгийн бонд, хоёр удаагийн долларын бондыг гаргаж нийт 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг хаалттай хүрээнд амжилттай босгож өглөө. Мөн бид Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-г Монголын Хөрөнгийн Бирж дээр урвуу нэгдэл хийх замаар бүртгүүлсэн анхдагч амжилтын эзэн болов.

Компанийн нийт харилцагчдын тоо 2017 оны эцсээр 14,991-т хүрээд байна. Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан хийсэн нийт арилжаа 9.9 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс 5.2 тэрбум төгрөг нь Засгийн газрын үнэт цаасны арилжаа дангаараа эзэлж байна. Үүнээс гадна,

хаалттай хүрээнд бид 8.6 тэрбум төгрөгийн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны арилжааг хийж гүйцэтгэсэн байна. Компанийн 2017 оны үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үнэлгээний дэлгэрэнгүй нийт ашиг 422 сая төгрөгт хүрсэн үзүүлэлттэй гарлаа.

Монгол Шуудан ХК

2017 онд Монгол Шуудан ХК орчин үеийн шуудангийн салбарын өнгө төрхийг тодорхойлох зорилгоор шуудангийн үйлчилгээний жишиг салбар байгуулан, шуудангийн салбарт мөрдөгдөх үйлчилгээний стандартыг боловсруулан туршиж ажилласан бөгөөд үйлчилгээний төрөлжилтийг бий болгох, орлогын шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор PostShor төслийн ажлыг Төв шуудан, жишиг салбаруудад эхлүүлэв.

Мөн Автотээврийн үндэсний төвтэй хамтран “Сонгинохайрхан” автотээврийн төв буюу Драгон төвд шуудангийн ачаа тээвэр, тээш хадгалалтын төвийг байгуулж, зорчигч тээврийн автобусаар явдаг дайвар ачааг нэгдсэн журамд оруулж, тээш илгээх, хадгалах үйлчилгээг эхлүүллээ. Энэ ажлыг мөн Дархан, Говь-Алтай зэрэг аймагт хэрэгжүүлж эхэллээ. Түүгээр барахгүй хэвлэл захиалгыг боловсронгуй болгох, бодит өртгийг бууруулах, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор postnews.mn сайтыг ашиглалтанд оруулав.

ТэнГэр Системс

2017 онд ТэнГэр Системс компани өөрийн үйл ажиллагааны чиглэлд стратегийн өөрчлөлт хийж уламжлалт технологийн байгууллага хэлбэрээс, блокчэйн технологи руу шилжиж, энэ төрөлд тэргүүлэх байгууллага болох зорилготой

ажиллаж эхэллээ. Энэ хүрээнд Блокчэйн Академийг байгуулж олон улсын мэргэжлийн багш нарын хамтаар чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, тэдэнтэй хамтран бодит төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2017 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн ТэнГэр Системс цахим банкны үйлчилгээ үзүүлэх үндэс суурийг тавьсан бөгөөд 2018 онд холбогдох төслүүдийг хэрэгжүүлэх болно. Ингэснээр Ард Санхүүгийн Нэгдэл цахим сувгуудаар банкны бүхий л үйлчилгээ үзүүлэх боломжийг хангах юм.

Ард Лайф

Ард Лайф бүтээгдэхүүн үйлчилгээгээ шинэчлэн зөвхөн Ард Санхүүгийн Нэгдлийн ажилчдад бус, бусад иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад хувийн тэтгэврийн сангийн бүтээгдэхүүнээ санал болгож эхэлснээр харилцагчдын тоо 870-д хүрч 163 хувиар, нийт тэтгэврийн хуримтлалын хэмжээ 113 хувиар өссөн үзүүлэлттэй ажиллалаа.

Нэгдэл компанийн хамтын ажиллагааны хүрээнд Ард Даатгал компанитай хамтран зөвхөн манай сангийн харилцагчид хамрагдах боломжтой маш сайн үнэлгээ бүхий эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын багцыг нэвтрүүллээ. Мөн харилцагчдынхаа санхүүгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Ард Актив ХЗХ-той хамтран тэтгэврийн хуримтлалаа барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнийг шинээр гаргав. Ингэснээр харилцагчид маань эрүүл мэндийн асуудал болон яаралтай санхүүгийн хэрэгцээгээ хуримтлалаасаа бус, даатгал болон зээлийн үйлчилгээгээр дамжуулан түргэн шуурхай авч санхүүгийн асуудлаа нэг дороос шийдэх боломжтой болов.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн

Хөрөнгө Оруулагч Үндэстэн компани нь 2016 оны 1 сард ирээдүйдээ хөрөнгө оруулж, Монгол орныхоо баялгийн эзэн болохоор сэтгэл шулуудсан 560 иргэн, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор анх удаагаа Фэйсбүүкээр дамжуулан олон нийтийн санхүүжилтийн аргачлалаар (краудфандинг) үүсгэн байгуулагдсан билээ. Өнгөрсөн хугацаанд Ард Санхүүгийн Нэгдлийн 7 хувьд хөрөнгө оруулж, 2017 оны 12 сарын 15-ны өдөр Жинст-Увс нээлттэй ХК-тай Монгол Улсад анх удаа урвуу хэлбэрээр нэгдэн МХБ дээр арилжаалагдаж эхэлсэн бөгөөд 2017 оны хаалтын ханш нь 1,858 төгрөгт хүрч хувьцаа эзэмшигчиддээ 85.8 хувийн өгөөжийг олгож чадлаа. Ингэснээр компанийн зах зээлийн үнэлгээ 3.1 тэрбум төгрөг хүрээд байна.

Ард Актив ХЗХ

Ард Актив ХЗХ-ны нийт хөрөнгө 1.4 тэрбум төгрөгт хүрч 121 хувиар, хадгаламжийн багц 157 хувиар, зээлийн багц 50 хувиар тус тус өссөн ба нийт гишүүдийн тоо 922-д хүрч өмнөх онтой харьцуулахад 22 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд бид Хоршооны дотоод бүтэц, удирдлага болон бүтээгдэхүүн үйлчилгээний багцдаа хэд хэдэн томоохон өөрчлөлт оруулсны нэг нь анхны үнийн дүнгийн хязгааргүй даатгагдсан хадгаламжтай хоршоо болж хадгаламжаа нэмэгдүүлж, эх үүсвэрийн өртгөө бууруулж ажиллалаа.

Ард Менежмент

Ард Менежмент нь Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниудын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэн үл хөдлөх хөрөнгийн борлуулалт, удирдлага, хэлцлийн гүйцэтгэл дээр ажилласан байна.

2017 оны II улирлын ТУЗ-ийн хурлаар хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулах шийдвэр гарч, сан үүсгэн байгуулах үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд энэхүү сан нь МХБ-ээр дамжуулан 5 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлж, МХБ-ээр дамжуулан хувьчлагдах болон IPO хийх компанид, I самбарын хувьцаанд, ЗГҮЦ-нд хөрөнгө оруулалт хийх юм. Үүнтэй холбоотойгоор сангийн бизнес төлөвлөгөө, өсөн нэмэгдэх тооцоолол, журам зэрэг баримт бичгийн төслийг боловсруулж, СЗХ-д сан үүсгэн байгуулах хүсэлттэй хавсарган хүргүүлсэн.

Ард Бит

Ард Бит криптовалютын салбарт олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулдаг биткойны банк болох Запа (Харо)-той хамтран биткойн зууч, цахим хэтэвч нээх ажиллагааг эхэлсэн бөгөөд арилжааг Монгол төгрөгөөр хийх боломжийг олгоод зогсохгүй криптовалюта болон зах зээлд судалгаа хийж ирэв. Одоогоор бид Ард Санхүүгийн Нэгдэл болон Хөрөнгө Оруулагч Үндэстэн компаниудын хөрөнгө оруулагчдад криптовалюта болон блокчэйн технологийн талаарх ойлголтыг өгч, үндсэн үйлчилгээгээ үзүүлэн ажиллаж байна.





Хувьцаа эзэмшигчдийн
бүтэц

#	Хувьцаа эзэмшигчид	ширхэг	Q4 2016	ширхэг	Q4 2017
1	Хишигдорж Батхишиг	1,689,415	11.94%	1,689,415	11.24%
2	Луна & Луна ХХК	1,450,801	10.25%	1,333,154	8.87%
3	Бруно Рашле	1,302,016	9.20%	1,317,337	8.76%
4	ВенчурсУан	1,304,043	9.21%	1,316,103	8.75%
5	Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК	1,056,359	7.46%	1,052,998	7.00%
6	Ард Секюритиз ХХК	-	-	820,910	5.46%
7	Чулуун Ганхуяг	1,132,000	8.00%	746,389	4.96%
8	Алтан Хоромсог ХХК	-	-	737,869	4.91%
9	Галням Уянга	224,679	1.59%	596,037	3.96%
10	Ард Лайф ХХК	-	-	596,037	3.96%
11	Сэдбазар Гэрэлтуяа	452,000	3.19%	452,000	3.01%
12	Ронок Лимитед	305,697	2.16%	305,697	2.03%
13	Лхагвасүрэн Соронзонболд	306,710	2.17%	272,656	1.81%
14	Мягмарсүрэн Золжаргал	251,000	1.77%	248,945	1.66%
15	Дагвабалжир Чулуунцэцэг	157,903	1.12%	157,903	1.05%
16	Интергруп Интернэйшнл ХХК	917,333	6.48%	-	-
17	МАК ХХК	873,000	6.17%	-	-
18	Баянжаргал Дэлгэржаргал	170,000	1.20%	70,000	0.47%
Нийт 15 (16) хувьцаа эзэмшигчид		11,592,956	81.92%	11,713,450	77.92%
Бусад хувьцаа эзэмшигчид		2,558,495	18.08%	3,320,424	22.08%
Саналын эрхтэй хувьцаа		14,151,451	100%	15,033,874	100%
Саналын эрхгүй хувьцаа		3,042,913		2,160,490	
Нийт гаргасан хувьцаа		17,194,364		17,194,364	

Орлогын тайлан

(Сая төгрөг)	Q4 2015	Q4 2016	Q4 2017
Нийт орлого	146,597	2,668,713	3,863,548
Нийт зардал	979,537	1,822,685	2,732,466
Татварын өмнөх ашиг	(636,067)	846,028	1,131,082
Татвар	(53,575)	100,043	107,278
Татварын дараах ашиг	(689,642)	745,986	1,023,805
Үнэ цэнийн өөрчлөлт	-	2,707,839	4,642,380
Ашиг	(689,642)	3,453,825	5,666,190

Баланс

(Сая төгрөг)	Q4 2015	Q4 2016	Q4 2017
Эргэлтийн хөрөнгө	17,578,353	10,136,391	8,441,467
Эргэлтийн бус хөрөнгө	22,316,933	29,255,978	41,214,859
Нийт хөрөнгө	39,895,286	39,392,369	49,656,326
Богино хугацаат өр төлбөр	5,889,185	1,593,890	2,470,179
Урт хугацаат өр төлбөр		352,512	4,073,993
Нийт өр төлбөр	5,889,185	1,946,402	6,544,172
Эздийн өмч	34,006,100	37,445,967	43,112,154

ТУЗ-ийн бүтэц



Пүрэвжаргал БАТБАЯР

ТУЗ-ийн дарга



Чулуун ГАНХУЯГ

Ард Санхүүгийн Нэгдэл ХК



БРУНО Рашле

Адвек



Нармандах МӨНХНАСАН

Монполимет ХХК



Жанчив ОЮУНГЭРЭЛ

Луна & Луна ХХК



Лхагвасүрэн СОРОНЗОНБОЛД

Худалдаа Хөгжлийн Банк



Одончимэд ОДБАЯР

Мон-Интернэйшнл ХХК



Хишигдорж БАТХИШИГ

Хишиг Арвин Индустириал ХХК



ЭНТОНИ Хоброу

ВенчурсУан БиВи



Хараат бус аудитын тайлан

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХК -ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Стандарт санал дүгнэлт

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК -ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн

дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг харууллага хүлээхгүй болно.



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2017.12.31.	2016.12.31.
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	5.1	689,066.4	166,192.2
Худалдааны ба бусад авлага	5.2	4,784,621.0	4,398,467.1
Урт хугацаат зээлийн авлага	5.2	2,015,297.7	5,151,485.4
Богино хугацаат зээлийн авлага	5.2	470,036.1	159,298.5
Богино хугацаат хөрөнгө оруулалт	5.3	107,539.5	49,695.2
Татвар, шимтгэлийн авлага	5.7	14,726.0	95.2
Бараа материал	5.9	23,175.5	31,718.5
Урьдчилж төлсөн зардал	5.8	423,914.0	179,438.9
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	5.4	1,220,000.0	3,000,000.0
Эргэлтийн хөрөнгийн дүн		9,748,376.2	13,136,391.0
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	5.10	627,821.1	676,748.5
Биет бус хөрөнгө (цэвэр)	5.11	246,216.5	17,560.7
Өмчийн хэрэглүүр	5.5	39,033,912.6	25,561,668.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		39,907,950.2	26,255,977.5
НИЙТ ХӨРӨНГӨ		49,656,326.3	39,392,368.2

ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Худалдааны ба бусад өглөг	5.6	1,300,720.0	766,981.4
Богино хугацаат зээлийн өглөг	5.6	1,080,072.9	742,334.7
Орлогын татварын өглөг	5.7	67,354.4	84,573.8
Урьдчилж оросон орлого	5.7	22,032.0	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн		2,470,179.3	1,593,889.7
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	5.6	2,781,782.5	-
Хойшлогдсон татварын өглөг	5.12	1,292,210.5	352,511.6
Урт хугацаат өр төлбөрийн дүн		4,073,993.0	352,511.6
Нийт өр төлбөр		6,544,172.3	1,946,401.3
Өөрийн хөрөнгө			
Энгийн хувьцаа	5.13	1,879,652.8	1,879,652.8
Халаасны хувьцаа	5.13	(160,216.4)	(160,216.4)
Нэмж төлөгдсөн капитал	5.13	9,929,060.7	9,929,060.7
Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц	5.13	7,350,220.9	2,707,838.6
Өмчийн бусад хэрэглүүр	5.13	13,799.1	13,799.1
Хуримтлагдсан үр дүн	5.13	24,099,636.9	23,075,832.2
Нийт өөрийн хөрөнгө		43,112,154.0	37,445,967.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		49,656,326.3	39,392,368.3



**ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2017.12.31.	2016.12.31.
Борлуулалтын орлого	5.15	2,088,000.0	11,795,101.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		-	(10,013,092.4)
Нийт ашиг		2,088,000.0	1,782,009.2
Борлуулалт, маркетингийн зардал	5.16	(201,182.3)	(135,270.0)
Ерөнхий удирдлагын зардал	5.17	(1,561,686.3)	(986,380.5)
Ажиллагсадтай холбоотой зардал	5.17	(565,232.3)	(564,232.9)
Бусад зардал	5.17	(10,339.3)	
Үйл ажиллагааны ашиг (алдагдал)		(250,440.1)	96,125.8
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	5.16	645,854.2	89,418.4
Санхүүгийн ашиг, (алдагдал) цэвэр	5.14	735,668.1	842,420.1
Бусад олз ба гарз		-	(3,099.5)
Татварын өмнөх ашиг (алдагдал)		1,131,082.2	846,028.0
Орлогын албан татварын зардал	5.18	(107,277.6)	(100,042.0)
Тайлант жилийн татварын дараах ашиг (алдагдал)		1,023,804.6	745,986.0
Бусад дэлгэрэнгүй орлого			
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт		5,500,841.0	3,010,452
Хойшлогдсон татварын зардал		(858,458.7)	(302,613)
Бусад олз, гарз			
Нийт дэлгэрэнгүй ашиг(алдагдал)		5,666,186.9	3,453,825
Нэгж хувьцаанд ногдо ашиг (алдагдал)		60.54	44.05



ӨМЧИЙН ӨӨРЧӨЛТИЙН ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Халаасны хувьцаа НТК	Нэмж төлөгдсөн капитал	БҮЦТ нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Өмчийн бусад хэрэглүүр	Нийт
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,879,652.8	(160,216.4)	(512,083.5)	10,441,144.0	-	22,343,804.9	13,799.1	34,006,100.9
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа								
Залруулагдсан үлдэгдэл	1,879,652.8	(160,216.4)	(512,083.5)	10,441,144.0	-	22,343,804.9	13,799.1	34,006,100.9
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)						745,986.0		745,986.0
Бодит үнэн цэнийн тохируулгын нөөцийн өсөлт, (бууралт)					2,707,838.6			2,707,838.6
Алдаа						(13,958.0)		(13,958.0)
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,879,652.8	(160,216.4)	(512,083.5)	10,441,144.0	2,707,838.6	23,075,832.9	13,799.1	37,445,967.5
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа								
Залруулагдсан үлдэгдэл	1,879,652.8	(160,216.4)	(512,083.5)	10,441,144.0	2,707,838.6	23,075,832.9	13,799.1	37,445,967.5
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)						1,023,804.6		1,023,804.6
Бодит үнэн цэнийн тохируулгын нөөцийн өсөлт, (бууралт)					4,642,381.9			4,642,381.9
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,879,652.8	(160,216.4)	(512,083.5)	10,441,144.0	7,350,220.5	24,099,637.5	13,799.1	43,112,154.0

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2017.12.31.	2016.12.31.
1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	1,131,082.2	846,028
Тохируулга:		
Элэгдлийн зардал	206,914.6	141,598
Хүүний орлого	(529,601.7)	(478,909)
Хүүний зардал	394,026.1	107,809
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарз	(12,271.7)	(89,186)
Хөрөнгө оруулалтын худалдсан олз	(524,039.6)	-
Хөрөнгө оруулалтын худалдсан гарз	10,879.2	-
Найдваргүй авлагын зардал	135.1	-
Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас хассаны гарз	11,367.0	(1,490)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	688,491.1	525,850
Бараа материалын өсөлт, бууралт	8,542.9	(26,163)
Урьдчилж төлсөн зардал, тооцооны (өсөлт)/бууралт	(43,568.2)	74,403
Худалдааны болон бусад авлагын (өсөлт)/бууралт	(3,043,261.4)	10,805,792
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт)	150,017.1	(5,750,478)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	-2,239,778.5	5,629,404

Хүүний төлбөрт төлсөн	543,595.1	478,909
Татварын байгууллагад төлсөн	(73,775.3)	(57,945)
Мөнгөөр төлөгдсөн хүү	(412,263.8)	(79,759)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,182,222.4)	5,970,609
2.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж	(17,074.3)	(10,475)
Худалдан авсан биет бус хөрөнгө	-	(15,386)
Худалдсан өмчийн хөрөнгө оруулалт	40,000.0	-
Худалдан авсан өмчийн хөрөнгө оруулалт	(179,795.0)	(5,021,643)
Олгосон зээл	(453,617.6)	(4,638,553)
Олгосон зээлийн эргэн төтөлт	401,823.4	1,781,523
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(208,663.5)	(7,904,534)
3.САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл авсан	4,022,821.7	1,760,000
Эргэн төлсөн зээл	(1,198,951.9)	1,018,271
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,823,869.8	741,729
Валютын ханшийн цэвэр өөрчлөлт	522,873.	30,268
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	89,889.8	(1,161,928)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	166,192.0	1,328,120
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	689,065.6	166,192



АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	2016	2017	Өөрч
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,610,491	5,960,989	65%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,005,045	1,564,298	56%
Авлага	2,397,641	2,577,136	7%
Зээлийн авлага	4,378,686	7,729,494	77%
Хугацаат бондоорхи Хөрөнгө оруулалт	821,782	1,118,490	37%
Бараа материал	64,329	41,990	-35%
Урьдчилж төлсөн тооцоо	829,867	1,664,551	101%
Борлуулах зорилготой хөрөнгө	97,600	1,626,929	100%
Эргэлтийн хөрөнгийн дүн	13,205,441	22,283,877	69%
Үндсэн хөрөнгө	1,365,479	3,297,520	141%
Биет бус хөрөнгө	50,390	45,564	-10%
Урт хугацаат зээлийн авлага	5,038,698	1,820,348	-64%
Хараат компани дахь хөрөнгө оруулалт	7,925,538	10,302,940	30%
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт	1,230,413	5,349,085	335%
Гүүдвил	5,490,594	6,187,485	13%
ХОЗ үл хөдлөх хөрөнгө	4,894,933		-100%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	25,996,045	27,002,941	4%
Нийт хөрөнгийн дүн	39,201,486	49,286,818	26%

Дансны өр	3,758,688	5,504,043	46%
Татварын өр	97,083	169,597	75%
Урьдчилж орсон орлого	3,021,361	3,996,100	32%
Богино хугацаат зээл	1,206,233	1,668,353	38%
Хүүний өр	-	415,558	100%
Эрсдлийн нөөц төлбөр	1,343,184	1,664,649	24%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,426,548	13,418,300	42%
Урт хугацаат зээл, өр төлбөр	200,000	690,038	245%
Хойшлогдсон татварын өр	56,038	64,329	15%
Урт хугацаат санхүүгийн түрээс өр	110,127	-	-100%
Урт хугацаат бусад өр төлбөр	-	4,975,093	100%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	366,165	5,729,459	1467%
Нийт өр төлбөрийн дүн	9,792,713	19,147,759	96%
Хувьцаат	1,879,653	1,879,653	0%
Халаасны хувьцаа	(471,579)	(532,287)	13%
Нэмж төлөгдсөн капитал	4,255,666	2,835,451	-33%
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	13,799	13,799	0%
Хуримтлагдсан ашиг	22,527,247	25,079,981	11%
Эздийн өмчийн дүн	28,204,785	29,276,597	4%
Цөөнхийн хувь оролцоо	1,203,988	862,461	-28%
Нийт эх үүсвэрийн дүн	39,201,486	49,286,818	26%



АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	2016	2017	Өөрчлөлт
Борлуулалтын орлого	19,293,905	10,810,365	-44%
Борлуулалтын өртөг	5,573,443	3,468,156	-38%
Нийт ашиг	13,720,462	7,342,209	-47%
Түрээс, менежмент орлого	45,401	129,883	186%
Хараат компанийн ногдох ашиг	394,126	371,654	-6%
Ногдол ашгийн орлого		269,334	100%
Хүүгийн орлого	973,546	1,200,580	23%
Бусад орлого	180,155	984,155	446%
Цэвэр орлогын дүн	15,313,690	10,297,815	-33%
Маркетинг сурталчилгааны зардал	274,890	436,452	59%
Цалин хөлс, шагнал урамшуулал	2,576,487	3,160,818	2%
Ерөнхий удирдлагын зардал	3,124,605	3,194,004	19%
Санхүүгийн зардал	113,239	483,769	327%
Бусад зардал	244,386	328,709	35%
Зардлын дүн	6,333,607	7,603,751	20%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	593,300	(196,980)	-133%
Хөрөнгө оруулалтын олз/гарз	166,932	728,688	337%

Биет,биет бус хөрөнгө борлуулсны олз (гарз)	(201,176)	86,472	-143%
Зээлийн эрсдлийн сангийн зардал	(131,478)	(140,591)	7%
Олз гарзын дүн	427,578	477,590	12%
Татварын өмнөх ашиг (алдагдал)	9,407,661	3,171,653	-66%
Орлогын татварын зардал	230,000	319,534	39%
Татварын дараах ашиг (алдагдал)	9,177,661	2,852,118	-69%
Хяналтын бус хувь оролцооны зардал	136,916	176,573	29%
Группын цэвэр ашиг	9,040,745	2,675,545	-70%
Нэгж хувьцаанд ногдох ашиг	658	199	-70%



АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Өмч хувьцаа	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Цөөнхийн хувь оролцоо	Нийт
	2016 оны 12 сарын 31	1,879,653	(471,579)	4,255,666	13,799	22,527,247	1,203,988	29,408,773
3	1 НББ алдаа өөрчлөлт					(122,812)		(122,812)
	Залруулсан Үлдэгдэл	1,879,653	(471,579)	4,255,666	13,799	22,404,435	1,203,988	29,285,962
	1 Тайлант үеийн ашиг					2,675,545	176,573	2,852,118
4	2 Хувьцаа халааслах		(60,708)	(1,420,214)				(1,480,922)
	4 Бизнес нэгдэл						(518,100)	(518,100)
A	2017 оны 12 сарын 31	1,879,653	(532,287)	2,835,451	13,799	25,079,981	862,461	30,139,059



АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2016	2017
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Нийт орох мөнгөн урсгал		21,042,956
Нийт гарах мөнгөн урсгал		16,068,958
Цэвэр мөнгөн урсгал	1,335,571	4,973,999
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ		
Борлуулсан үндсэн хөрөнгө	555,848	62,715
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	(1,063,434)	(191,213)
Хөрөнгө оруулалтын орлого	146,872	1,128,872
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(6,071,707)	(2,891,008)
Бусдад олгосон зээлийн төлөлт	907,329	11,141,312
Бусдад олгосон зээл урьдчилгаа	(3,269,258)	(13,401,842)
Хүлээн авсан хүүгийн орлого	1,575,978	1,830,704
Хүлээн авсан ногдол ашиг		83,009
Цэвэр мөнгөн урсгал	(7,218,372)	(2,237,451)
Санхүүжилтын мөнгөн гүйлгээ		
Зээл авсан, үнэт цаас гаргасан	4,823,659	6,953,138
Зээл өрийн бичиг төлөлт	(1,247,858)	(4,523,685)
Хяналтын бус хувь оролцоог авсан	(1,568,060)	(222,359)
Ногдол ашиг төлсөн		(55,550)
Цэвэр мөнгөн урсгал	2,007,741	2,151,544
Валюын ханшийн зөрүү		(374)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,875,060)	4,888,092
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	7,485,551	1,073,272
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,610,491	5,960,989



[illegible]

ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ



Ердийн даатгал



Банк бус санхүүгийн
байгууллага



Брокер, диллер, андеррайтер
хөрөнгө оруулалтын зөвлөх



Тэтгэврийн сан



Хадгаламж зээлийн
хоршоо



Хөрөнгө оруулалтын
менежмент



Хөрөнгө оруулалтын сан



Криптовалютын арилжаа



Санхүүгийн сургалт



Шуудангийн цогц
шийдэл



Санхүүгийн програм хангамж



Үл хөдлөх хөрөнгийн
түрээс



info@ardholdings.mn



ardholdings.mn



хөтөч.лугших.бүтээлчид



7707 8181